



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/536

Улаанбаатар хот

Хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ардын хувьсгалын 96 жилийн ой, Үндэсний их баяр наадмын өдрүүдэд нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Шөнийн гудамж”-ийн ажиллах цагийн хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан үйл ажиллагаатай холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг доор дурдсан байгууллага, албан тушаалтанд даалгасугай:

2.1.баяр наадмын өдрүүдэд холбогдох хуваарийн дагуу зохион байгуулагдах урлагийн тоглолт, шоу арга хэмжээний үеэр худалдаа, үйлчилгээний чанарт хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд, эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангахад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т, хэв журам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн газар /Ж.Эрдэнэболд/, Нийслэлийн Замын хөдөлгөөний хяналтын газар /Б.Эрдэнэбат/-т тус тус;

2.2.мөн өдрүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж ажиллахыг Нийслэлийн Онцгой байдлын газар /Н.Уламбаяр/-т тус тус;

2.3.“Шөнийн гудамж”-д зохион байгуулагдаж байгаа урлагийн тоглолт, шоу арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж, сурталчлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Э.Дагиймаа/-т.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД

111020002494

Нийслэлийн Засаг даргын 2017 оны
07 дугаар сарын 06-ны өдрийн
24536 дугаар захирамжийн хавсралт



АРДЫН ХУВЬСГАЛЫН 96 ЖИЛИЙН ОЙ, ҮНДЭСНИЙ ИХ БАЯР
НААДМЫН ӨДРҮҮДЭД “ШӨНИЙН ГУДАМЖ”-ИЙН
АЖИЛЛАХ ЦАГИЙН
ХУВААРЬ

№	Сар, өдөр	Ажиллах цаг
1	2017 оны 07 дугаар сарын 09-ний өдөр	20:00-23:59
2	2017 оны 07 дугаар сарын 10-ны өдөр	00:00-06:00 20:00-23:59
3	2017 оны 07 дугаар сарын 11-ний өдөр	20:00-23:59
4	2017 оны 07 дугаар сарын 12-ны өдөр	20:00-23:59
5	2017 оны 07 дугаар сарын 13-ны өдөр	00:00-06:00 20:00-23:59
6	2017 оны 07 дугаар сарын 14-ний өдөр	00:00-06:00 20:00-23:59
7	2017 оны 07 дугаар сарын 15-ны өдөр	00:00-23:59
8	2017 оны 07 дугаар сарын 16-ны өдөр	00:00-06:00